

Баян-Агт сумын Цэцэрлэгт төлөвлөгөөт хяналт шалгалт
хийсэн тухай

Хяналт шалгалтын зорилго

Булган аймгийн засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын баталсан 2017 оны 10 сарын 06-ны өдрийн 01/20 дугаар удирдамжийн дагуу санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон бусад холбогдох дүрэм, журам, тушаалуудын хэрэгжилтыг хангуулах, үндсэн үйл ажиллагааны байдал, зохион байгуулалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны байдлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх, ололт амжилтыг бататгаж, зөрчил дутагдлыг арилгахад оршино.

Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ц.Алтанхуяг
2017 оны 11 дүгээр сарын 06-аас ажлын 6 хоног.

Шалгалтанд хамрагдсан байгууллага, объектын нэр

Баян-агт сумын Жавхаа Цэцэрлэгийн 2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаа хамрагдав.

**Шалгалтанд хамрагдсан объектын талаарх
товч мэдээлэл**

Булган аймгийн Баян-агт сумын 6-р багт байршилтай Цэцэрлэг нь 18 ажиллагсадтай ба үүнээс Эрхлэгч багш 1, багш 4, туслах багш 4, дуу хөгжмийн багш 1, тогооч 2, нярав 1, үйлчлэгч 1, галч 4 гэсэн орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

2016 онд 1-р гарын үсгийг эрхлэгч Б.Даваажав, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Б.Оюун-эрдэнэ нар зурж төрийн санд бүртгэлийн 100040115201 тоот данс, 100040115402 тоот нэмэлт санхүүжилтын данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох "CTS" программаар бүртгэж хөтөлсөн байна.

Өмнөх шалгалтын талаар

Булган аймгийн Аудитын газраас тус газрын 2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна гэж дүгнэжээ.

**Шалгалтын явцад хийгдсэн ажил,
шийдвэрлэсэн асуудал**

Тус байгууллагын 2016 оны касс, харилцахын баримт, няравын тайлан, нягтлан бодох бүртгэлийн журнал, эрхлэгчийн тушаал, цалин олгох хүснэгт,

нийгмийн даатгалын болон татварын, санхүүгийн тайлан, цалингийн карт зэрэг баримт материалуудад тулгуурлан Эрхлэгч Б.Даваажав, Нягтлан бодогч Б.Оюун-эрдэнэ, нярав М.Гантулга нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийлээ.

Санхүүжилт, орлогын талаар:

2016 онд Сумын Цэцэрлэг төсвөөс 199986,1 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн ба 203652,1 мянган төгрөг авч үйл ажиллагааны зардалд 203652,1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын тайлангаар:

2016 оны Сумын Цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 429464,4 мянган төгрөгөөс 10854,0 мянган төгрөгний барилга байгууламж, 1554,5 мянган төгрөгний тоног төхөөрөмж, 477,7 мянган төгрөгний тавилга хэрэгсэл хасагдаж жилийн эцэст 416578,2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

2016 онд Сумын Цэцэрлэгийн бараа материалын эхний үлдэгдэл 72853,9 мянган төгрөг дээр 553,2 мянган төгрөгний бичиг хэргийн материал, 13057,4 мянган төгрөгийн аж ахуйн материал, 4200,0 мянган төгрөгний шатах тослох материал, 25979,0 мянган төгрөгний хүнсний материал нэмэгдэж 803,0 мянган төгрөгний бичиг хэргийн материал, 13852,5 мянган төгрөгний аж ахуйн материал, 232,0 мянган төгрөгний сэлбэг хэрэгсэл, 4515,0 мянган төгрөгний түлш шатах тослох материал, 31461,8 мянган төгрөгний хүнсний материал үйл ажиллагаандаа зарцуулж оны эцэст 65779,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

Өглөг, авлагын талаар

2016 онд өглөг, авлагагүй тайлан баланс гарсан байна.

Төсөвт зардлын талаар /мян.төг/

2016 онд Сумын Цэцэрлэг төсөвт зардлыг 199986,1 мянган төгрөгөөр төлөвлөсөн, гүйцэтгэлээр 203652,1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2016 онд Сумын Цэцэрлэг нийт төсвийн зардлын 65,2 хувь буюу 132870,2 мянган төгрөгийг цалин хөлс нэмэгдэл урамшуулалын зардалд, 7,2 хувь буюу 14616,6 мянган төгрөгийг ЭМНДШимтгэлийн зардалд, 0,6 хувь буюу 1264,1 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд, 1,4 хувь буюу 2890,9 мянган төгрөгийг гэрэл цахилгааны зардалд, 4,1 хувь буюу 8417,6 мянган төгрөгийг түлш халаалтын зардалд, 12,9 хувь буюу 26244,3 мянган төгрөгийг хоолны зардалд, 1,3 хувь буюу 2607,0 мянган төгрөгийг зөөлөн эдлэл нормын хувцас худалдан авах зардалд, 1,6 хувь буюу 3211,8 мянган төгрөгийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан тэтгэмжийн зардалд тус тус зарцуулж, 1965,5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Шилэн дансны нэгдсэн сайтад Цэцэрлэг нь 2017 оны 01-09-р сарын төсвийн төлөвлөгөө гүйцэтгэлийг байршуулсан байна.

Хоолны өдөрлөг дэх хүүхдийн тооны талаар

2016 оны хоолны өдөрлөг дэх хүүхдийн тоог багшийн журналын ирцийн бүртгэлтэй тулгаж үзэхэд зөрүүгүй байна.

Махны орлого зарлагын талаар

2016 оны эхний үлдэгдэл 1012,6 кг 4,752,593 төгрөг дээр 1897,7 кг 8,439,750 төгрөгийн орлого авч 2305,7 кг 11,086,115 төгрөгний мах зарлага гаргаж оны эцэст 604,6 кг 2,106,228 төгрөг үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

Шалгуулагчийн ололттой болон дэвшилтэй тал

1. Санхүүгийн баримт болон эрхлэгчийн тушаалыг үдэж, архивласан байна.
2. Төсвийн хөрөнгөөр болон хандив тусламжаар ирсэн хөрөнгийг тухай бүрд нь бүртгэж, данс бүртгэлд тусгасан.
3. Авлагагүй, өглөггүй ажилласан.
4. Төсвийн тухай хуулийн 8.9.1 дүгээр зүйлийн дагуу санхүүгийн тайланг хугацаанд нь зөрчилгүй гаргадаг.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, шалтгаан

1. Жолоочийн тооцооны хуудас бичигддэггүй, нягтлан бодогч тооцоо бодолт хийдэггүй, нярав шатахууны тайланг авсан шатахуундаа тааруулан гаргадаг, хүнснээс бусад материалд агуулахын бүртгэл хөтлөөгүй, хоолны өдөрлөг, няравын тайланг нягтлан бодогч хянаж хүлээн авч гарын үсэг зурдаггүй, шатахууны үнэд шилжүүлсэн мөнгийг санхүүгийн тайланд шууд зарлага болгодог байгаа зэрэг нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13,1-д / Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, мөн хуулийн 13.5-д /Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно./, 13.7-д /Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./ заасан заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2. Цалингийн тооцооны хүснэгт болон гарт олгох хүснэгт дээр гарын үсгийн бүрдэл дутуу.

3. Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг хамт олны хурлаар хэлэлцүүлж, тушаалаар баталгаажуулаагүй байна.

4. Шалгалтаар эрхлэгчийн 2016 оны 09 сарын 26 ны А/20 тоот тушаалаар ур чадварын нэмэгдэл олгохдоо хувь хэмжээг буруу тооцож:

№	Нэрс	Үндсэн цалин	Олгосон хувь	Олгосон ур чадвар	Олговол зохих хувь	Олговол зохих ур чадвар	Илүү олгосон ур чадвар
1	Л.Хандсүрэн	469,105	100	469,105	30	140,732	328,+373
2	Л.Цэрэндолгор	419,582	80	335,666	30	125,875	209,791
3	Б.Бямбасүрэн	539,547	80	431,638	30	161,864	269,774
4	Д.Идэржаргал	539,547	40	215,819	30	161,864	53,955
5	Б.Үүрийнуяа	416,521	60	249,913	30	124,956	124,957
6	С.Баярмаа	550,369	100	550,369	30	165,111	385,258
7	Д.Отгонцэцэг	535,286	60	321,172	30	160,586	160,586
8	Г.Батгэрэл	416,521	40	166,608	30	124,956	41,652
9	Б.Оюун-эрдэнэ	556393	40	222,557	25	139,098	83,459
ДҮН				2,962,847		1,305,042	1,657,805

1,657,805 төгрөгийг илүү олгосон байгаа нь 2010 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал,

хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 362/112/183 дугаар тушаалын хавсралтын 4-т /Ур чадварын нэмэгдлийн хэмжээг ур чадварын шалгуур үзүүлэлтийн хангалтын хувь, түвшнээс хамааруулан тухайн албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн 10-30 хувь байхаар тогтооно./, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 63/104 тоот хамтарсан тушаалаар баталсан “Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам ”-ын 3-т /Ур чадварын нэмэгдлийн дээд хэмжээ нь тухайн албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн 25 хувиас ихгүй байна./ заасан заалтуудыг тус тус зөрчсөн байна.

5. Шилэн дансны нэгдсэн сайтад Цэцэрлэг нь 2017 оны 3-р улиралд 112 мэдээлэл байршуулахаас 109 мэдээлэл байршуулж 3 мэдээлэл огт мэдээллээгүй, 15 мэдээлэл хоцроож мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.2-д /Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 сарын 25-ны өдрийн дотор, сар, улиралын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор/, мөн хуулийн 8.2-д /Төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ/ заасан заалтуудыг зөрчсөн байна.

6. Нягтлан бодогч Б.Оюун-эрдэнэ нь Сургуулиас 4-р улиралд үр дүнгийн урамшуулал 45 хувиар авсан бөгөөд Цэцэрлэгээс давхардуулан ажлын үр дүнг үнэлж дүгнээгүй 35 хувиар 194,738 төгрөгийн үр дүнгийн урамшуулал авсан байгаа нь Монгол улсын засгийн газрын 393 тоот тогтоолоор баталсан журмын 2.1-д /Үр дүнгийн урамшлыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас сургалтын багш, бусад албан хаагчийн ажлыг үнэлж, дүгнэх чиглэлээр баталсан журмуудад заасан шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласны төлөө олгоно./ заасан заалтыг зөрчсөн байна.

**. Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа,
зөвлөгөө өгсөн байдал**

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар улсын байцаагчийн 2 актаар 1,852,543 төгрөгийн төлбөр тогтоов.

Зөрчил дутагдлыг арилгуулж, таслан зогсоох зорилгоор 3 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Дүгнэлт

Тус байгууллагад Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.7 дахь заалтууд, Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн нөхөх заавар”-ын хэрэгжилт хангалтгүй байна.

Анхан шатны баримтуудын гарын үсгийн бүрдэл дутуу, нярав шатахууны тайланг дутуу гаргасан, шатахууны тайланг нягтлан бодогч шалгаж хүлээн аваагүй, нярав нь агуулахын бүртгэлийг хүнснээс бусад материалд хөтлөөгүй, няравын тайлангуудыг нягтлан бодогч хянаагүй, шалгаж хүлээж авдаггүй байгаа нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих дотоодын хяналт хийгдээгүй ажлын хариуцлага сул байгааг харуулж байна.

Цаашид авах арга хэмжээний санал

1. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, улсын байцаагчийн актаар тогтоогдсон төлбөрийг хугацаанд нь барагдуулж, мэргэжил арга зүйн зөвөлгөөг биелүүлж ажиллах

2. Дотоодын хяналт шалгалтыг сайжруулж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

БИЧСЭН:

САНХҮҮ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ц.АЛТАНХУЯГ